

# ДОТООДЫН

**ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО  
ХОНОГИЙН ТОЙМ**



2026.07.06

## Дотоодын зах зээлийн онцлох мэдээ

## ТОВЧ

- "Unlock the Mongolian Economy" чуулганы үеэр 545 сая ам.долларын хөрөнгө оруулалтын гэрээнүүд байгууллаа.
- Оюу толгой төслийн зээлийн хүү буурч, Монголын тал 2026 онд анхны ногдол ашгаа хүртэхээр боллоо.
- 2026 оны эхний хагас жилд ТОП-20 индекс оны эхнээс 3.1%-иар буурлаа.
- Ногдол ашиг зарласан компаниудын 34 нь нийт 985.3 тэрбум төгрөгийн ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдэд олгоод байна.

## МХБ-ийн индексийн өгөөж

Индекс	Долоо хоног	Сар	Жил
ТОП 20	-1.43%	-2.37%	-4.96%
MSE A	-0.28%	-1.91%	-4.29%
MSE B	-0.56%	-0.48%	-1.89%

2026/06/29 – 2026/07/03

## Идэвхтэй арилжаалагдсан үнэт цаас

Симбол	Үнийн дүн
GLMT	863,722,734.00
KHAN	703,668,607.00
INV	291,514,425.00
AARD	272,278,994.00
MGLA	250,365,793.50

2026/06/29 – 2026/07/03

## Өндөр өсөлттэй үнэт цаас

Симбол	Хаалтын ханш	Өсөлт %
TNGR	2,600.00	15.56%
BUK	253.00	15.00%
SHG	1,690.00	14.97%
MDR	258.00	14.67%
TEE	20,300.00	14.62%

2026/06/29 – 2026/07/03

2026 он 07-р сарын 06

Зах зээлийн  
үнэлгээ тэрбум ₮

13,485

ТОП-20 индекс

51,773

MSE A

19,930

MSE B

14,091



## МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ДНБ өсөлт

7.9%

2026 - I улирал

Инфляц

11.2%

2026-05 сар

ГВУН(сая\$)

7,656.16

2026-06 сар

Бодлогын  
хүү

12.0%

ЗГ-ын бондын  
өгөөж

5.3%

USD/MNT

3,581.94

2026-06-07

 **Эдийн засгийн мэдээлэл****“UNLOCK THE MONGOLIAN ECONOMY”: ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ШИНЭ БОЛОМЖУУД**

Монгол Улсын Ерөнхий сайдын дэргэдэх Эдийн засгийн зөвлөлийн “Unlock the Mongolian Economy” өргөтгөсөн хуралдаан 6-р сарын 29-30-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулагдаж, төр, хувийн хэвшил болон олон улсын хөрөнгө оруулагчдын төлөөллийг нэг дор цуглуулсан томоохон арга хэмжээ боллоо.



Арга хэмжээнд дотоодын хувийн хэвшлийн төлөөллүүдээс гадна дэлхийн олон орны 120 гаруй хөрөнгө оруулагч оролцсон бөгөөд эхний өдрийн хүрээнд нийт 545 сая ам.долларын хөрөнгө оруулалтын дүн бүхий зургаан хамтын ажиллагааны гэрээ, санамж бичигт гарын үсэг зурсан нь онцлох үр дүн байв.

Үүнээс гадна, 65 тэрбум ам.долларын хөрөнгө удирддаг Сингапурын Phillip Capital сан Монгол Улсад албан ёсны төлөөлөгчийн газраа байгуулахаар шийдвэрлэсэн бол Унгарын OTP банк Монголд салбар нээх хүсэлтээ Ерөнхий сайд Н.Учралд албан ёсоор гардуулсан нь гадаадын санхүүгийн байгууллагуудын Монголын зах зээлд хандах сонирхол нэмэгдэж буйг илтгэв.

**ЗАСГИЙН ГАЗАР: ОЮУ ТОЛГОЙ ТӨСЛӨӨС НОГДОЛ АШИГ АВАХААР БОЛЛОО**

Монгол Улсын Засгийн газар болон Rio Tinto компанийн хэлэлцээрийн үр дүнд Оюу толгойн төслийн хувь нийлүүлэгчдийн зээлийн хүүг 10.5%-иас 7.9% болгон бууруулж, Монголын тал 2026 онд анхны ногдол ашгаа хүртэхээр боллоо.

Зээлийн хүү ийнхүү буурснаар төслийн нийт хугацаанд 6.2 тэрбум ам.долларын санхүүгийн зардал хэмнэгдэж, Монголын талын хүртэх өгөөж 8.7 их наяд төгрөгөөр нэмэгдэх тооцоо гарсан байна. Мөн санхүүгийн нөхцөлийг дахин хэлэлцэх хугацааг 7 жилээс 3 жил болгон богиносгожээ.

Үүнээс өмнө Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням Rio Tinto компанийн ТУЗ-ийн дарга Доминик Бартонтой уулзах үеэр Монголын тал ногдол ашгийг ирэх намраас эхлэн олгож эхлэх хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн байна.



## Зах зээлийн мэдээлэл

## МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ: ХАГАС ЖИЛИЙН ХОЛИМОГ ГҮЙЦЭТГЭЛ

2026 он гарснаас хойш Монголын хөрөнгийн зах зээл нэлээд хэлбэлзэлтэй, чиглэл нь тодорхойгүй байдалтай өнгөрлөө. 6-р сарын 30-ны байдлаар ТОП-20 индекс оны эхнээс 3.1 хувиар буурч 53,031.6 нэгжид хүрсэн бөгөөд зах зээлийн нийт дүр зураг тэнцүүхэн хуваагдсан байна. Өөрөөр хэлбэл индексэд багтсан 20 компаниас 10 нь өсөлттэй, үлдсэн 10 нь уналттай байжээ.

Хүснэгт: ТОП-20 компанийн эхний хагас жилийн хувьцааны гүйцэтгэл

Тикер	Хаалтын үнэ	Өөрчлөлт*	Тикер	Хаалтын үнэ	Өөрчлөлт*
XAC	1,265.00	31.2%	APU	969.22	-0.8%
MSE	368.29	18.0%	GOV	222.00	-1.0%
QPAY	272.80	17.6%	INV	8,895.00	-1.2%
MNDL	81.35	17.5%	UID	3,028.00	-9.7%
KHAN	1,450.00	5.1%	SBM	441.06	-10.0%
AARD	3,450.00	4.2%	LEND	154.05	-10.6%
MGLA	251.42	2.6%	GLMT	1,155.00	-13.3%
TUM	375.75	2.2%	MLG	159.64	-16.0%
TTL	32,040.00	1.8%	CUMN	265.71	-16.2%
SUU	628.61	0.9%	TDB	14,290.00	-25.7%

\*2026 оны 6-р сарын 30-ны хаалтын үнийг 2025 оны 12-р сарын 31-ний хаалтын үнэтэй харьцуулан тооцоолсон болно.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

## НОГДОЛ АШГИЙН ЗАХ ЗЭЭЛД ЦӨӨН КОМПАНИ ДАВАМГАЙЛЖ БАЙНА

МХБ-д бүртгэлтэй компаниудын дунд ногдол ашиг олголт жил ирэх тусам илүү тогтвортой болж байгаа боловч ногдол ашиг тараахаа зарладаг компанийн тоо нэг хэвийн өсдөггүй, жилээс жилд хэлбэлздэг. 2025 оны цэвэр ашгаас хувьцаа эзэмшигчдэдээ ногдол ашиг олгохоор шийдсэн компаниуд нийт бүртгэлтэй компаниудын ердөө гуравны нэг орчим хувийг эзэлж байна.

Хүснэгт: Ногдол ашиг хуваарилалт


Он	Хуваарилсан ХК	Нийт дүн (₮)	Өөрчлөлт
2023	47	911.0 тэрбум	—
2024	46	1,236.0 тэрбум	+35.7%
2025	48	1,002.5 тэрбум	-18.9%

Эх сурвалж: Маркет инфо

2025 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн 48 компанийн хүрээнд нийт дүн ойролцоогоор 1.0 их наяд төгрөгт хүрсэн бөгөөд үүнээс 2026 оны 7-р сарын эхний байдлаар 34 компани ногдол ашгаа хувьцаа эзэмшигчдийн дансанд шилжүүлээд байна. Олгогдсон нийт дүн 985.3 тэрбум төгрөгт хүрч, нийт шийдвэрлэсэн дүнгийн 98 хувийг бүрдүүлжээ.

## ДОТООДЫН ХУВЬЦААНД ХЭЗЭЭ ХӨРӨНГӨ ОРУУЛАХ ВЭ?

ТОП-20 индексийн сарын дундаж хэлбэлзэл (2015-2025)



Монголын ТОП-20 индексийн дундаж хэлбэлзлээс харахад 1-3 сар, 7-9 сар, 12 саруудад өсөлт давамгайлдаг байна.

### Ямар стратеги баримтлах вэ?

- Ногдол ашиг хүртэхийг зорьж буй бол 1-3 сард хувьцаа худалдаж авах нь тохиромжтой.
- Хямд үнээр хувьцаа авах боломж хайж байгаа бол 4-5 сард зах зээлийн уналтыг ашиглах хэрэгтэй.
- 7-9 сард зах зээл өсөх магадлалтай тул эрт худалдан авч, өсөлтийг ашиглах боломжтой.
- Жилийн эцэст (12-р сар) дунд хугацааны өсөлт ажиглагдах хандлагатай тул урт хугацааны хөрөнгө оруулалтад тохиромжтой үе.

### Ногдол ашигт суурилсан хөрөнгө оруулалт хийхэд мэдэж байх ёстой өдрүүд

Компаниудын хувьцааг эзэмшиж ногдол ашиг авахын тулд доорх өдрүүдийг зайлшгүй мэдэж байх ёстой. Монгол улсын хувьд Т+2 төлбөр тооцооны системийн дагуу гүйлгээ хийгддэг учраас бүртгэлийн өдрөөс 2 хоногийн өмнө тухайн хувьцааг худалдаж аван ногдол ашиг авах боломжтой болдог.

Зарлах өдөр /Declare date/	Хувьцаа авсан байх өдөр /Ex-Dividend date/	Бүртгэлийн өдөр /Record date/	Төлбөрийн өдөр /Payable date/
2026.02.19 өдөр ТУЗ-ийн тогтоолоор зарласан.	2026.03.20 өдөрт амжиж ХЭ болсон байх ёстой.	2026.03.22 өдөр ногдол ашиг авах эрхтэй ХЭ-н жагсаалт гаргана.	2026.04.30 өдөр ҮЦТХТ дансаар олгоно.

Энэ нь ямар нэг компанийн бодит жишээ биш бөгөөд зохиомол өдрүүд болно.